



**Bers ABS
plus**

“БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК” ХХК-ИЙН 2024 ОНЫ 1-Р ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Тайлан бэлтгэсэн:

"Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК (Хөрөнгө итгэмжлэн удирдагч)

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Соёлын Төв Өргөө /14200/, 10 давхар, 1005 тоот
Утас: +976-70122346

Гарын үсэг:

Х.Маргад-Эрдэнэ /Гүйцэтгэх захирал/

Тайланг баталсан:

Гарын үсэг:

Б.Болор-Эрдэнэ /"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн дарга/



Агуулга

| | |
|---|---|
| 1. ХБҮЦ-ны мэдээлэл | 3 |
| 2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл..... | 4 |
| 3. Төлөөлөн удирдах зөвлөл..... | 5 |

1. ХБҮЦ-НЫ МЭДЭЭЛЭЛ

"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК нь 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид "СЗХ" гэх)-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (цаашид "ХБҮЦ" гэх) гаргах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд "Бэрс Финанс ББСБ" ХХК-ийн 100 хувь эзэмшлийн охин компани юм.

"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) нь хараат бус 2 гишүүн, хараат 1 гишүүн, нийт 3 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн даргаар Б.Болор-Эрдэнэ, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Д.Ганхүрэл, ТУЗ-ийн хараат гишүүнээр С.Отгонбат нар, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК ажиллаж байна.

"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК нь 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдөр 9.0 тэрбум төгрөгийн дүн бүхий ХБҮЦ-ыг СЗХ-нд бүртгүүлж 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд амжилттай арилжсан бөгөөд 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн.

Хүснэгт 1. ХБҮЦ-ны ерөнхий мэдээлэл

| Мэдээлэл | Үзүүлэлт |
|---|------------------------------|
| ХБҮЦ гаргагч | "Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК |
| Улсын бүртгэлийн дугаар | 9011845634 |
| Регистрийн дугаар | 6949886 |
| ХБҮЦ-ыг бүртгэсэн СЗХ-ны тогтоолын огноо | 2023/03/31 |
| ХБҮЦ-ыг бүртгэсэн авсан СЗХ-ны тогтоолын дугаар | 88 |
| ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ (төг.) | 50,000 |
| ХБҮЦ (ширхэг) | 90,000 |
| ХБҮЦ-ны үлдэгдэл (сая төг.) | 4,500 |
| ХБҮЦ-ны хүүгийн хувь (жилийн) | 19.2% |
| ХБҮЦ-ны хүү төлөх давтамж | Улирал бүр |
| ХБҮЦ-ны хүү тооцох хоног | 365 хоног |

Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК нь 2024 оны эхний хагас жилд ХБҮЦ-ны үндсэн төлбөрт 4.5 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 866.37 сая төгрөгийг хуваарийн дагуу төлсөн байна. ХБҮЦ-ны үлдэгдэл хугацаанд Хүснэгт 2-т харуулсан төлбөрийг төлнө.

Хүснэгт 2. ХБҮЦ-ны төлөлтийн талаарх мэдээлэл

| № | Огноо | Үндсэн төлбөр | Хүүгийн төлбөр | Үлдэгдэл |
|------|------------|------------------|----------------|------------------|
| 1 | 2024/07/28 | - | 215,408,219.18 | 4,500,000,000.00 |
| 2 | 2024/10/28 | - | 217,775,342.47 | 4,500,000,000.00 |
| 3 | 2025/01/28 | - | 217,775,342.47 | 4,500,000,000.00 |
| 4 | 2025/04/28 | 4,500,000,000.00 | 213,041,095.89 | - |
| Нийт | | 4,500,000,000.00 | 864,000,000.00 | |

2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл

2024 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар хөрөнгийн багцын хэмжээ 2023 оны эцсийн үлдэгдлээс 46.44 хувиар буурсан бөгөөд энэ нь ХБҮЦ-ны үндсэн төлбөрийн 50 хувь буюу 4.5 тэрбум төгрөгийг хуваарийн дагуу 2024 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр төлсөнтэй холбоотой юм.

Хүснэгт 3. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын ерөнхий шинж чанар

| Хөрөнгийн багцын шинж чанар | 2023.12.31 | 2024.06.30 | Өөрчлөлт |
|--|-------------------|--------------------|----------|
| Багцын үлдэгдэл | 8,892,899,844.11 | 4,763,234,579.84 | -46.44% |
| Зээлийн дундаж үлдэгдэл | 9,551,986.94 | 11,674,594.56 | 22.22% |
| Хамгийн өндөр дүнтэй 1 зээлийн багцад эзлэх хувь | 0.60% | 1.69% | 1.09% |
| Хамгийн өндөр дүнтэй 10 зээлийн багцад эзлэх хувь | 5.65% | 10.68% | 5.03% |
| Багц дахь зээлүүдийн Ж.Д.Хүү /жил/ | 41.53% | 40.62% | -0.91% |
| Багц дахь зээлүүдийн Ж.Д.ЗҮХ | 46.10% | 40.81% | -5.29% |
| Багц дахь зээлүүдийн Ж.Д.Насжилт /сар/ | 9.09 | 11.01 | 21.18% |
| Багц дахь зээлүүдийн Ж.Д.Үлдэгдэл хугацаа /сар/ | 35.25 | 32.46 | -7.91% |
| Сарын дундаж төлбөрийн дүн | 688,181.87 | 831,359.89 | 20.81% |
| Зээлдэгчдийн сарын дундаж орлого | 5,267,868.03 | 6,191,662.19 | 17.54% |
| Зээлийн тоо | 931 | 408 | -56.18% |
| Зээлдэгчийн төрөл | Иргэн | Иргэн | - |
| Барьцаа хөрөнгийн төрөл | Автомашин | Автомашин | - |
| Барьцаа хөрөнгийн үнэлгээ | 23,435,140,790.00 | 13,827,339,000.00 | -41.00% |
| Чанаргүй зээлийн хувь | 0.22% | 0.00% | -0.22% |
| Багц дахь зээлүүдийн эргэн төлөлт Үүнээс: (өсөн нэмэгдсэн дүнгээр) | 9,663,375,122.42 | 15,205,922,637.35* | - |
| Зээлийн үндсэн төлбөр | 7,625,157,079.39 | 11,941,627,477.11 | - |
| Хүүгийн төлбөр | 2,034,264,102.69 | 3,258,321,555.53 | - |
| Нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр | 3,953,940.34 | 5,973,604.71 | - |

*Хөрөнгийн багц дахь зээлүүдийн 2024 оны 6 дугаар сарын эргэн төлөлт болох 891.8 сая төгрөгийг гэрээний дагуу 2024 оны 7 дугаар сарын 03-ны дотор тооцоо нийлж, баталгаажуулан хуваарьт өдөр ТЗК-д шилжүүлнэ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь "Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг ХБҮЦ-ны төлбөрийг төлөх хугацаатай уялдуулан арилжааны банкуудад хадгаламж хэлбэрээр байршуулж ажилласан бөгөөд 2024 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар ТЗК-ийн хадгаламжийн үлдэгдэл 0.0 төгрөг, харилцах дансны үлдэгдэл 23.53 сая төгрөг байна

Тайлант хугацаанд "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК нь "Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн хөрөнгийн багцад өөрчлөлт орсон талаарх мэдээллийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тухай журам"-ын 11.3-т заасны дагуу СЗХ-нд мэдэгдэж ажилласан.

Хүснэгт 4. ХБҮЦ-ны хөрөнгөөр багцад орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл

| № | Өөрчлөлт орсон мэдээлэл | Зээлийн тоо | Зээлийн дүн |
|-------------|--|-------------|-------------------------|
| 1 | Хаагдсан | 393 | - |
| 2 | Хугацаа хэтэрсэн тул буцаан шилжүүлсэн | 175 | 1,591,191,250.54 |
| 3 | Багцад нэмж бүртгэсэн | 83 | 1,777,996,383.99 |
| Нийт | | 651 | 3,369,187,634.53 |

3. Төлөөлөн удирдах зөвлөл

“Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийг “Бэрс Финанс ББСБ” ХХК нь бүрэн эзэмшдэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь ганц хувьцаа эзэмшигч “Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч) байна.

2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 22/24а/02 тоот шийдвэрээр ТУЗ-ийн гишүүнээр С.Отгонбат, Б.Болор-Эрдэнэ болон Д.Ганхүрэл нарыг тус сонгож 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ТУЗ-ийн хурлаар хараат бус гишүүн Б.Болор-Эрдэнийг ТУЗ-ийн даргаар томилсон.

Тайлант хугацаанд ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 6 удаа хуралдаж холбогдох тогтоолыг баталсан. Үүнд:

Хүснэгт 5. ТУЗ-ийн шийдвэр, хэрэгжилт

| № | Огноо | ТУЗ-ийн шийдвэрийн агуулга | Хэрэгжилт |
|---|------------|--|---|
| 1 | 2024.01.10 | Санхүүгийн болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайлан баталгаажуулах тухай | 2023 оны 4 дүгээр улирлын санхүүгийн үйл ажиллагааны тайлан болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг тус тус баталж СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт хүргүүлсэн. |
| 2 | 2024.01.16 | Хадгаламжийн данс нээлгэх тухай | Богд банкинд хадгаламжийн дансыг нээлгэж ХИУ-д холбогдох эрхийг олгов. |
| 3 | 2024.03.25 | Үйл ажиллагааны зардлын төсвийг батлах тухай | Компанийн 1 дүгээр улирлын үйл ажиллагааны зардлын төсвийг батлав. |
| 4 | 2024.04.10 | Санхүүгийн болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайлан баталгаажуулах тухай | 2024 оны 1 дүгээр улирлын санхүүгийн үйл ажиллагааны тайлан болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг тус тус баталж СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт хүргүүлсэн. |
| 5 | 2024.04.25 | Жилийн үйл ажиллагааны тайланг батлах тухай | 2023 оны жилийн үйл ажиллагааны тайланг баталж СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт хүргүүлсэн. |
| 6 | 2024.05.06 | Үйл ажиллагааны зардлын төсвийг батлах тухай | Компанийн 2 дугаар улирлын үйл ажиллагааны зардлын төсвийг батлав. |